

ТА ИНТЕРНЕТ БАНК БОЛОН 319708, 319709
УТСААР ХОЛБОГДОН ВАЛЮТЫН ХАНШ
ТОХИРОХ БОЛОМЖТОЙ.

2022.02.24

Онцлох мэдээ

- ОХУ-ын ерөнхийлөгч Владимир Путин Украины эсрэг хатуу сануулга өгч, Донбасст цэргийн тусгай ажиллагаа явуулахыг зөвшөөрсний дараа ам.доллар, алт, газрын тосны ханш огцом өсөж дэлхийн хувьцаанууд болон АНУ-ын бондын өгөөжүүд унав.
- Сан Францискогийн Холбооны Нөөцийн банкны ерөнхийлөгч Мэри Дейли энэ онд АНУ-ын төв банк инфляцийг улам дордохоос нь өмнө бодлогын хүүг дор хаяж 4 удаа, магадгүй түүнээс ч олон удаа өсгөнө гэж төсөөлж буйгаа илэрхийлжээ.

Валютын зах зээл

ОХУ-ын Украин дахь бүрэн хэмжээний эзлэн түрэмгийллийн тухай айдас нэмэгдэж эрсдэл ихтэй Австрали доллар зэрэг валютууд сулрах зуур евро 3 долоо хоногийн доод түвшинд хүрлээ. ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин Донбасст цэргийн ажиллагаа явуулахыг зөвшөөрснөөр биткойн 1 сарын доод, фунт стерлинг 1 долоо хоногийн доод, рубль 2 жилийн доод түвшинд тус тус очлоо. Евро 0.35% унаж 1.1265 буюу 02.03-наас хойших доод цэгт хүрэв. Австрали болон Шинэ Зеланд долларууд харгалзан 0.62%; 0.64% буурч 0.7187; 0.6730 боллоо. Рубль 2020.03-р сараас хойших хамгийн сул 81.571 ханшинд хүрч, хамгийн сүүлчийн байдлаар 87.70 хүртэл сулраад байна. Фунт мөн адил 0.17% алдаж 1.3522-той тэнцлээ.

Зах зээлд эрсдэл багатай хөрөнгүүдийн эрэлт нэмэгдэж эхэлснээр Хятадын юань ам.долларын эсрэг 4 жилийн дээд түвшинд эргэлдэж байна. Өдрийн дундад оффшор юань 6.3132-р арилжаалагдаж байв.

Алтны зах зээл

Пүрэв гарагт алтны ханш долоо хоногийн эхэнд хүрээд байсан 9 сарын дээд цэг рүү тэмүүлж байна. Украин онц байдал зарлаж Барууны улсууд Орос оронд хориг тавьснаар хөрөнгө оруулагчид эрсдэл багатай хөрөнгө рүү орж эхэллээ. Өглөө 1 унц алтны ханш 0.3% өсөлттэй 1,912.40 ам.доллар байсан бол одоо 1,942.21 ам.доллар хүрээд байна. Ам.долларын фьючерс GCv1 0.2% өсөлттэй 1,913.20 ам.доллартай тэнцүү байсан юм.

Зэсийн зах зээл

ОХУ-ын ерөнхийлөгч В.Путины цэргийн ажиллагаа явуулах тушаалын дараа цаашид Москвад илүү чанга хориг тавьж магадгүй байдал Лондонгийн хөнгөн цагааны ханшийг өсгөлөө. Мөн Лондонд зэсийн үнэ бага зэрэг нэмэгдсэн байна. Лондонгийн Металлын Биржийн зэсийн фьючерс 0.2% дээшилж тонн нь 9,887 ам.долларт арилжаалагдах зуур Шанхайн Фьючерсийн Бирж дээрх зэсийн фьючерс 0.5% унаж 70,940 юань боллоо.

Валют	Ханш	24ц өөрч.		
EUR/USD	1.127	-0.33%		
USD/CNY	6.3115	-0.16%		
USD/RUB	81.1425	0.01%		
USD/JPY	115.03	0.02%		
USD/KRW	1199.35	0.49%		
AUD/USD	0.7196	0.24%		
GBP/USD	1.3523	0.00%		
Индекс	Нэгж	24ц өөрч.		
Dow Jones	33131.8	-1.38%		
S&P 500	4225.5	-1.84%		
NASDAQ	13037.5	-2.57%		
FTSE 100	7498.2	0.05%		
Nikkei 225	26161.5	-1.09%		
DAX	14631.4	-0.42%		
Hang Seng	23258.0	-1.70%		
Метал	Ханш (USD)	24ц өөрч.		
Алт	1919.66	0.56%		
Мөнгө	24.84	1.16%		
Нүүрс (Чин хуанг дао)	163.99	0.00%		
Зэс (LME)	9866	-0.49%		
Төмрийн хүдэр	692.50	-1.07%		
Газрын тос (NYME)	93.54	1.56%		
LIBOR	Хүү	24ц өөрч.		
US 1M LIBOR	0.18%	8.56%		
US 3M LIBOR	0.49%	5.17%		
US 6M LIBOR	0.78%	3.05%		
US 12M LIBOR	1.29%	2.45%		
Бонд	Хүү	24ц өөрч.		
US Treasury 10Y	1.94%	-2.36%		
UK Treasury 10Y	1.48%	0.54%		
GE Treasury 10Y	0.23%	-6.17%		
JP Treasury 10Y	0.21%	4.06%		
Бонд (Монгол)	Хүү	Дуусах огноо	Өгөөж	24ц өөрч.
Чингис	5.13%	12/5/2022	3.10%	0.03%
Гэрэгэ	5.63%	5/1/2023	3.38%	-0.10%
МУХБ 2023	7.25%	10/23/2023	4.40%	-0.05%
Хуралдай	8.75%	3/9/2024	3.96%	-0.05%
ММС	9.25%	4/15/2024	24.80%	-1.10%
МИК 2024	8.85%	8/2/2024	11.42%	-0.01%
Номад	5.13%	4/7/2026	4.74%	-0.16%
Монгол 27	3.50%	7/7/2027	4.98%	-0.22%
Монгол 31	4.45%	7/7/2031	5.43%	-0.24%
Самурай JPY	1.52%	12/25/2023	0.04%	0.00%

Хувьцаа Ханш 24ц өөрч.

Turquoise Hill Resources	19.84	-2.17%
Mongolian Mining Corp	2.08	0.97%
Erdene Resource Dev	0.42	0.00%
Centerra Gold	11.8	1.03%

Макро эдийн засаг (Монгол) Огноо Дүн

Инфляцийн түвшин	2022 (I)	14.6%
Бодлогын хүү	2022 (I)	6.5%
Банк хоорондын зах зээлийн хүү	2021 (XII)	6.08%
Хадгаламжийн дундаж хүү (төг)	2022 (I)	7.78%
Хадгаламжийн дундаж хүү (валют)	2022 (I)	2.26%
Зээлийн дундаж хүү (төг)	2022 (I)	15.5%
Зээлийн дундаж хүү (валют)	2022 (I)	9.21%

Ханшийн таамаглал

Валют	Q1 22	Q2 22	Q3 22	Q4 22	2023
EUR/USD	1.12	1.13	1.15	1.16	1.19
GBP/USD	1.35	1.36	1.37	1.38	1.40
USD/CNH	6.38	6.35	6.40	6.41	6.28
USD/JPY	115	115	116	116	115
USD/RUB	76.0	75.0	75.0	73.0	75.0

Түүхий эд

Алт	1800	1750	1707	1690	1650
Зэс	9620	9350	9400	9500	9550
Нүүрс	131.5	105.0	92.5	84.0	71.5

Эдийн засгийн голлох тоо мэдээ эх сурвалж: Блүүмбэрг

Өмнөх өдрийн үр дүн Үр дүн Таам. Өмнөх

EU HICP Final YY	5.1%	5.1%	5.1%
EU HICP Final MM	0.3%	0.3%	0.4%
FR Business Climate Mfg	112.0	112.0	112.0

Өнөөдөр хүлээгдэж буй мэдээ Цаг Таам. Өмнөх

US New Home Sales-Units	23:00	0.806M	0.811M
US Initial Jobless Claims	21:30	235k	248k
US GDP 2nd Estimate	21:30	7.0%	6.9%
KR Bank of Korea Base Rate	9:00	1.25%	1.25%

Маргааш хүлээгдэж буй мэдээ Цаг Таам. Өмнөх

US Durable Goods	21:30	0.8%	-0.7%
US Consumption, Adjusted MM	21:30	1.5%	-0.6%
GE GDP Detailed YY	15:00	1.4%	1.4%
GE GDP Detailed QQ	15:00	-0.7%	-0.7%
JP CPI, Overall Tokyo	7:30	-	0.5%

Газрын тосны зах зээл

ОХУ-аас Украин руу дайрснаар газрын тосны ханш 2014 оноос хойш анх удаа баррель нь 100 ам.долларыг давлаа. Дэлхийн хоёр дахь том газрын тос нийлүүлэгч ОХУ дайралтыг эхлүүллээ гэж хэвлэлийнхэн мэдээлж байна. Brent газрын тосны ханш 5.4 хувь өсөж 102.06 ам.доллар орчимд арилжаалагдаж байна.

Бондын зах зээл

5 жилийн өрийн бичгийн дуудлага худалдаа эрэлт сайтай байж, хувьцааны зах ойрын хугацаанд хямралтай байсан хэдий ч олигтой өсөлт аваагүй АНУ-ын засгийн бондын арилжаа их хэмжээтэй өнгөрлөө. Пүрэв гарагт 7 жилийн хугацаатай өрийн бичиг дуудлага худалдаагаар 50 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээгээр арилжаалагджээ. Нийт АНУ-ын засгийн өгөөжийн муруй 2-4 нэгжээр буурсан нь Мягмар гарагийн 2 жилийн хугацаатай бондын дуудлага худалдаатай холбоотой юм. 2 жил, 7 жил болон 30 жилийн хугацаатай бондууд 2 орчим нэгжээр буурч 9 сараас хойших дээд цэгтээ хүрээд байна.

Хөрөнгийн зах зээл

ОХУ дайн эхлүүлснээр дэлхийн хөрөнгийн зах зээл маш хүчтэй унаж эхэллээ. Тухайлбал S&P500 индекс 2.5 хувь, Nasdaq 100 индекс 3 хувь унаж, технологийн салбар баавгай зах зээлийн хөдөлгөөнийг нэгэнт үзүүлж эхэллээ. Европын хөрөнгийн зах зээл одоогоор 4 хувь унасан байгаа бол Азийн зах зээл 2020 оноос хойших хамгийн доод түвшинд очлоо. Мэдээж ОХУ-ын хөрөнгийн зах зээл түр хугацаанд арилжааг хориглосон ба хувьцаанууд түүхэнд байгаагүйгээр унасан байна.

Мэдэгдэл

Энэхүү мэдээлэл нь ХХБ-ны нэрийн өмнөөс тус банкны харилцагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгддэг бөгөөд аливаа нэг гадаад валют, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах болон хөрөнгө оруулалтийг санал болгоогүй болно. Мөн энэхүү мэдээлэл нь аль нэгэн харилцагчийн хөрөнгө оруулалтанд, санхүүгийн байдал болон тусгайлсан эрэлт, хэрэгцээнд тулгуурлаагүй бөгөөд ХХБ нь энэхүү мэдээллийн үнэн зөв болон бодит байдлад ямарваа нэгэн баталгаа гаргахгүй ба мэдээллийг ашигласнаас үүдэн бий болох аливаа алдагдал, сөрөг үр дагаварт харуцлага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Энэхүү мэдээлэл нь зохиогчын эрх бүхий мэдээллүүдийг агуулж буй тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, гуравдагч этгээдэд түгээхийг хатуу хориглоно. Хэрэв энэхүү мэдээллийг цаашид хүлээн авахаа зогсоохыг хүсвэл гарчиг хэсэгт "UNSUBSCRIBE" гэж бичин ут и-мэйлд харуу илгээнэ үү.